

ҮНДЭСЛЭЛ:

Монгол улсын эдийн засаг хурдтай өсөж халдварт бус өвчин, осол гэмтлийн тоо ихсэж осол гэмтлээс шалтгаалсан нас баралт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Эмнэлгийн яаралтай тусламжийн чанар хүртээмж хангалттай бус, шинээр тасаг нэгжийг бүх шатны эмнэлгүүдэд 2012 оноос байгуулж эхэлсэн юм.

Яаралтай тусламжийн үндсэн мэргэжлийн эмчийг бэлтгэх сургалт 2014 оноос эхлэн зохион байгуулагдаж эхэлсэн бөгөөд ерөнхий мэргэжлийн, дотрын, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний эмч, сувилагч, бусад эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн болон эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийг одоогийн байдлаар ард иргэдэд үзүүлж байна.


Сүүлийн үед яаралтай тусламжийн тасаг нэгжид ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдэд чиглэсэн богино хугацааны сургалт эрчимтэй хийгдэж байгаа хэдий ч яаралтай тусламжийн төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулах зорилгоор тэдний мэдлэг, дадлыг үнэлж цаашдын хэрэгцээг тодорхойлох шаардлагатай байна.

Зорилго: Улаанбаатар хотын анхан болон хоёр дахь шатлалын эмнэлгүүдэд яаралтай тусламжийн мэргэжлээр ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, сургалтын чанарыг үнэлэх

Аргачлал: 88 эмч, эмнэлгийн мэргэжилтнээс асуумжийн аргаар судалгааг авч тэдний мэдлэг, дадлыг үнэлэн судлав.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Судалгаанд оролцсон нийт оролцогчдын 10% /8/ эрэгтэй 90% нь /80 /эмэгтэй оролцогчид байв. Насны хувьд оролцогчдын **36% нь 20-29 насны**, 28,4% нь 40-49 насны, 18,1% нь 30-39 насны, 17% нь 50-59 насны оролцогчид эзэлж байна.

Зураг-1 Сургалтад хамрагдсан байдал

Сургалтанд хамрагдсан хугацааг судлахад 63.6% нь 2010-2014 онд, 10,2% нь 2005-2009 онд, 2,2% нь 2000-2004 онд суралцаж төгсчээ.

Сургалтыг оролцогчдын 30.6 % нь АШУҮИС-д, 27,2% нь ЭМХТ-өөс бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан багц цагийн сургалтад, 4,5% нь дүүргийн эмнэлгүүдэд, 3,4% УНТЭ, 2,2 % Түргэн тусламжийн төвөөс, 1,1% нь УГТЭ-ээс зохион байгуулсан сургалтад хамрагдсан гэж хариулсан байна.

Сургалтын чанарыг Ликертийн шалгуураар 51,1% нь хангалттай, 28,4% нь дунд зэрэг, 11,3% нь хангалттай сайн, 2,2% нь хангалтгүй гэж үнэлжээ.

Сургалтын хөтөлбөрийн агуулгыг 57,9% нь хангалттай, 19,1 % нь дунд зэрэг, 13,6% нь хангалттай сайн, 2,2% нь хангалтгүй гэж дүгнэв.

Сургалтын орчинг үнэлэхдээ 36,3 % нь дунд зэрэг, 35,2% нь хангалттай 11,3% нь хангалттай сайн, 3,4% нь хангалтгүй байсан гэж үзэв.

Багшийн чадавхийг оролцогчдын 61,3% нь хангалттай, 14,7% нь хангалттай сайн, 9,0% нь дунд зэрэг, 2,2% нь хангалтгүй гэж үнэлсэн бол сурагчид өөрсдийн оролцоог үнэлэхдээ 37,5% нь хангалттай, 35,2 % нь дунд зэрэг, 6,8% нь хангалттай сайн, 2,2% нь хангалтгүй гэж үнэлжээ.

Судалгаанд оролцогчдын яаралтай тусламжийн талаарх мэдлэгийг 28 асуултаар шалгахад 54,3%-тай байв.

Сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний 54,5% нь амилуулах дадлага 1-2 удаа хийх бололцоо сургалтын явцад олдсон бол 17% нь 3-4 удаа, 17% нь 5-аас дээш удаа хийх боломж олдсон байна.

Эмнэлгийн орчинд амилуулах суурь тусламж үзүүлж байсан уу? гэсэн асуултад нийт оролцогчдын 44,3% нь тийм гэж хариулсан бол эдгээр эмнэлгийн мэргэжилтний 76,9% нь 1-2 удаа, 25,6% нь 5-10 удаа, 15,3% нь 2-4 удаа өвчтөнд үзүүлсэн гэж хариулжээ.

Эмнэлгийн бус орчинд амилуулах суурь тусламж үзүүлж байсан уу? гэсэн асуултад нийт оролцогчдын 22,7% нь тийм гэж хариулж бүгд 1-2 удаа хийж бүгд амжилттай болсон гэж дурьдсан байна.

ДҮГНЭЛТ:

Улаанбаатар хотын өрхийн болон дүүргийн эмнэлэгт яаралтай тусламжийн тасагт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний дөнгөж 7.4% нь үндсэн мэргэжлийн, 3.4% нь төрөлжсөн мэргэжлээр мэргэшиж 48% нь богино хугацааны багц цагийн сургалтад хамрагдаж 23% нь сургалтад огт хамрагдаагүй нь мэргэжилтэй ажиллах хүчин дутагдалтайгаас гадна, эмнэлэг доторх яаралтай тусламжийн мэргэжлийн үйл ажиллагаа хангалттай түвшинд явагдахгүй байна.

Сургалтыг 30,6%-ыг АШУҮИС-дангаараа, богино хугацааны сургалтыг мэргэжлийн нийгэмлэг холбоод ЭМХҮТ-тэй хамтран зохион байгуулдагыг судалгааны дүн харуулж байгаа боловч клиникийн эмнэлгүүд, Яаралтай тусламжийн төв зэрэг мэргэжлийн байгууллагын оролцоо бага.

Гадаадын улс орнуудад яаралтай тусламжийн сургалтад судалгаанд оролцогчдоос нэг ч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаагүй байна.

Сургалтын чанар, сургалтын хөтөлбөр, багшийн чадавхийг оролцогчдын 56,9% нь хангалттай гэж үзэж байгаа бол, 36,9% нь сургалтын орчин, өөрсдийн оролцоог хангалттай гэж үзжээ.

Сургалтанд хамрагдсан оролцогчдын яаралтай тусламжийн суурь мэдлэгийг үнэлэхэд 54,3%, сургалтын явцад дадлагажсан үзүүлэлт 54,5% байгаа нь сургалтын чанар, хүртээмж хангалттай бус байгааг илтгэж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Яаралтай тусламжийн мэргэшүүлэх сургалтыг олон улсын стандартад нийцүүлэх
2. Багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, сургалтын орчинг шинэчилснээр сургалтын чанарыг сайжруулж суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх
3. Чадварлаг боловсон хүчнийг бэлтгэснээр яаралтай тусламжийн чанарыг сайжруулах
4. Яаралтай тусламжийн мэргэжлийн байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэн хамтын ажиллагааг сайжруулах